



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 12 дугаар сарын 17–ны өдрийн 418 дугаар тогтоолоор батлагдсан “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.8, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

1/ Журмын 3.8 дахь хэсэг

“Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компани нь төлбөрийн чадварын үзүүлэлтийн тайлан болон санхүүгийн тайланг цаасан болон цахим хэлбэрээр дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ”.

2/ Журмын 4.3 дахь хэсэг

“Андеррайтер, үнэт цаасны брокер дилерийн компани Хорооноос тогтоосон төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг гурван удаа дараалан санхүүгийн тайлангийн жилд хангаж ажиллаагүй тохиолдолд тухайн компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авна”.

2. Журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт “өөрийн гишүүнчлэл бүхий өөрийгөө зохицуулах байгууллагад” гэснийг “Хороо болон өөрийн гишүүнчлэл бүхий өөрийгөө зохицуулах байгууллагад” гэж өөрчилсүгэй.

3. Мөн журмын 4.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Журамд орсон энэхүү өөрчлөлтийг 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭГТЭГЧ,
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

